

# СОЛОНГОСЫН СОЁЛЫН ДАВАЛГАА, МОНГОЛЫН ЗАЛУУЧУУДАД ҮЗҮҮЛЖ БУЙ НӨЛӨӨ

Ц. Батцэрэн

Дэд профессор, Доктор (Ph.D)  
ШУТИС, Бизнесийн Удирдлага,  
Хүмүүнлэгийн Сургууль

**Ц**ахим ертөнцийн хөгжил нь дэлхийн улс орнуудын соёлын даяаршлын үйл явцыг хурдасгах нэгэн хүч болсон. Өнөөдөр Монгол оронд Солонгосын соёл, урлаг хурдацтай түгэн дэлгэрч байна. Иймээс Монголын залуучуудад Солонгосын соёлын үзүүлж буйг нөлөөг судлах зорилгоор 16-45 насны залуусын дунд анкет, фокус ярилцлагыг ашиглан судалгаа явуулан үр дүнд SWOT анализын аргыг ашиглан дүгнэлтийг хийсэн болно.

1. Соёл нь хүний байнгын идэвхитэй чөлөөт сэтгэлгээ бүтээлч үйл ажиллагааны үр дүнд бий болж уламжлагдаж байдаг хэм хэмжээ, итгэл үнэмшил, бэлгэдэл, үнэт зүйлсийн цогц мөн. Аливаа улс үндэсний орших байх, хүлээн зөвшөөрүүлэх өвөрмөц шинж чанар байдаг. Улс үндэстний соёл, уламжлал нь түүхэн цаг хугацааны явцад бүтээгдэж цаг хугацаа орон зайг туулан шалгарч үлдсэн үнэт зүйлсийн тогтолцоо юм. Хүмүүс болон үндэстний өмнө тавигдах асуултын дотроос хамгийн чухал “Бид хэн бэ?” гэсэн асуулт байдаг ч, харнултыг хаанаас хайх нь тодорхойгүй. Учир нь хүмүүс өөрсдийнхөө өвөг дээдэс, шашин, хэл, үнэт зүйлс, ёс заншил, институтынхээ түүхээс улам бүр хөндийрөн өөрийгөө тодорхойлж, өөрсдийгөө овог аймаг, угсаатны бүлэг, шашны нийтлэг, үндэстэн зэрэг соёлын нийтлэгүүд буюу хамгийн өргөн утгаар иргэншилтэй адилтгахыг эрмэлзсээр ирсэн. Өөрсдийн тодотгол шинжээ тодорхойлж чадаагүй хүмүүс нь ашиг сонирхлоо хамгаалах зорилгоор улс төрийн бодлогыг ашиглах чадваргүй байдаг. Бид юуны өмнө өөрсдийн хэн биш вэ? гэдгийг мэдэж байж хэн болохоо мэддэг, тэгээд дараа нь хэний эсрэг болохоо ухаардаг<sup>1</sup> хэмээсэн байдаг.

Өнөө үед, дэлхийн бодлогын гол тоглогчид нь улс үндэстэнүүд хэвээр байна. Тэдний үйл хэргийн хүчирхэгжих, хөгжих цэцэглэх хүсэл эрмэлзэл нь урьдын адил байгаа ч соёлын дээдлэл, нийтлэг болон ялгаануудыг бас тодорхойлох болов. Өмнөд Азийн улс орнууд өнөөдөр эдийн засгаа сайжруулж, цэрэг зэвсгийн хүч, улс төрийн нөлөөгөө бэхжүүлэх үндэс суурьтай болоод байна. Өрнийн бус

<sup>1</sup> Самуэл Хантингтон. Орч. Иргэншил хоорондын мөргөлдөөн, Ази-Америкийн хүйтэн дайн, х.3.

улс орнууд ийнхүү хүчирхэгжихийн хэрээр өөртөө итгэдэг болж өөрсдийн үнэт зүйлсийг улам бэхжүүлж, өрнийхний “тулгасан” зүйлсийг няцаах болов. “ХХI зууны олон улсын систем нь АНУ, Европынхон, Хятад, Япон, Орос, магадгүй Энэтхэг гэсэн зургаан их гүрэн, бусад улсуудаас бүрдэх болно<sup>2</sup> гэж Хенри Киссинжер тэмдэглэсэн байдаг. Киссинжерийн хэлсэн зургаан гүрэн нь таван өөр иргэншилд хамаарахаас гадна нөлөө бүхий оролцогч болох Исламын улс орнууд гэж бас бий. Энэхүү шинэ ертөнц дэх бүс нутгийн бодлого нь угсаатан болон арьс өнгөний хамааралтай бодлого байх болно. Даяаршлын бодлого бол иргэншлийн бодлого мөн. Их гүрнүүдийн өрсөлдөөн иргэншил хоорондын мөргөлдөөнөөр солигдлоо хэмээн үзсэн байдаг. “Соёлуудын мөргөлдөөн улам ихэсч байгаа нь өнөө үеийн түүхэнд урьд хожид үзэгдээгүй аюул тарьж мэднэ” хэмээн Вацлев Хавел онцолсон бол, “Ирээдүйд болох мөргөлдөөний гал нь эдийн засаг, үзэл суртлын гэхээсээ илүү үндэсний хүчин зүйлсээс бадарч мэднэ”<sup>3</sup> гэж Жак Делор санал нийлжээ. 1980-аад оны сүүлээс коммунист ертөнц задарч, “Хүйтэн дайн”-ы үеийн олон улсын систем түүх болж үлдэв. “Хүйтэн дайны дараах ертөнц дэх хүмүүсийн гол ялгаа нь үзэл суртал, улс төр, эдийн засаг байхаа болив. Соёлын ялгарал чухал болж ирсэн ба даяаршлын тухай судлаж буй судлаачид уг үйл явцын нэг шинжид илүү анхаарсан. Тэрхүү хэт анхаарал татаж буй шинжид Монгол мэт жижиг үндэстний хувьд даяаршлал нь уламжлалт зан заншил соёлоо алдах айдас болж байна гэсэн үзэл юм.

Харин даяаршлын үеийн соёлын дэлгэрэлтийн талаар Нью Йоркийн их Сургуулийн профессор Аржун Аппадурай өөр саналтай байна. Түүний үзэж байгаагаар өнөөдрийн даяаршлын холбоо харилцаанд тулгамдаад байгаа нэг гол асуудал нь нэг талаас соёлын нэгдэлшил (homogenization) нөгөө талаас олоншил (heterogenization) хоёр болно. Ялангуяа нэгдшлийн тухай ойлголт түгээмэл болж байгаа бөгөөд голдуу мэдээллийн хэрэгслийн судалгаанд гарч ирдэг. Өөрөөр хэлбэл, мэдээллийн технологи өндөр хөгжиж дэлхий нийтийг мэдлэг мэдээллээр хангасны үр дүнд нэгдшлийн үйл явц бий болоод байгааг хэлж байна.<sup>4</sup> Нэгдшил гэдэг нь цаашлаад америкшил болон өргөн хэрэглээний барааны нэгдшил мэтээр ойлгодог. Эхнийх нь Америкийн соёлын нөлөө дэлхийд тархаж байгаа тухай асуудал, харин өргөн хэрэглээний бараа дэлхий нийтэд адил болсон нь соёлуудын нэгдших гол шалтгаан. Монголд Солонгосын соёл дэлгэрсэн ч Солонгос болох бус, харин Солонгосын хэв маягийг хөгжүүлсэн соёлын хэв маяг бий болно гэсэн үг юм.

<sup>2</sup> Henry A. Kissinger. *Diplomacy* (New York: Simon & Schuster, 1994), pp.23-24.

<sup>3</sup> Vaclav Havel. *The New Measure of Man*, New York Times, 8 July 1994, p.A27;

Jacques Delors. *Questions concerning European Security*, Address, International institute for Strategic Studies, Brussels, 10 September 1993, p.26

<sup>4</sup> Г. Мөнх-Эрдэнэ. “Даяаршил шинэ колониизм биш: Монгол дахь олон талт байдал”, Даяаршлын үеийн соёл ба миграци. Олон улсын хурлын эмхэтгэл, УБ. 2012, 145х.


Түүнчлэн үндэстэн улс түүнд багтаж бусад угсаатны цөөнхөө нэгдшилд оруулж байгаа зэрэг олон түвшний төстэй боловч ондоо зүйл байгааг өнөө үед хялбарчилж даяаршил (simplification) гэж нэрлээд байна. Мөн тэрээр харагдах байдал, хувцаслалт, бие биеийнхээ хэлийг мэддэг болох зэргээр нэгдшил явагдаж байгаа хэрэг боловч энэ нэгдшил нь аль нэг улс оронд очихлоороо тухайн улсын төр, соёл, эдийн засагт идэгдэж ондооших үйл явцад орж нэгдших бус олоншил бий болон үл авалцах, үл зохицон нийцэх байдал бий болдог байна. Ийм үл холбогдох байдлыг, ондоошлыг гол үүсгэгч нь төр байдаг байна. Аппадурай улс орон, төр бие биендээ машид нээлттэй харилцаатай болсон нь нэгдшлийг эхлүүлж байгаа бөгөөд энэ нэгдшил нь эргээд тэд өөрсдийн өвөрмөц байдлаа хадгалах сэдлийг бий болгож уран сэтгэмжийн нийгмээ үргэлжүүлэн байгуулах уран сэтгэмжийг өдөөж энэ нь олоншлыг бий болгодог<sup>5</sup> гэжээ. Энэхүү даяаршлын нэгдшил, олоншлын үйл явц сүүлийн жилүүдэд Монголын нийгэм, соёлын хүрээнд ч өрнөөд байгаа билээ.

2. 1990 онд Монгол ардчилсан орон болсон нь дэлхийн улс орнуудтай нийгэм, улс төр, эдийн засгийн харилцах харилцааг тэлсэн үйл явдал байлаа. Түүнчлэн Монголчуудад дэлхийд хөгжлөөрөө тэргүүлэгч гадны улс орнуудын шинжлэх ухаан, техник, соёлын хөгжлөөс суралцах өргөн бололцоог олгож өгсөн. Ардчилсан орон болсноос хойш гадаадын улс оронд зорчих Монгол иргэдийн тоо хэмжээ жил ирэх тусам нэмэгдсээр байгаа билээ. Тухайлбал 2015 оны эхний есөн сард Монгол Улсын 1,467,061 иргэн гадаадад зорчсон бол энэ оны эхний есөн сард 1,657,792 иргэн гадаад улс руу зорчиж, өмнөх оны мөн үеэс 13 хувиар өссөн үзүүлэлттэй байна.<sup>6</sup>

<sup>5</sup> Мөн тэнд.

<sup>6</sup> Монголчууд гадаадын аль улс руу хамгийн их зорчиж байна вэ? Эх сурвалж: Гадаадын Иргэн Харьяатын Газар. Oct 6, 2016. <http://www.shuurhai.mn/127314>

## Хүснэгт 1



Иргэдийн хамгийн их зорчсон улсуудын эрэмблэн үзвэл БНХАУ, ОХУ гуравдугаарт БНСУ орж байна.

## Хүснэгт 7.

Гадаад улсад зорчсон Монгол Улсын иргэд /Эхний аравт эрэмбэлэгдсэн улсууд/			
д/д	Зорчсон улс	2015 оны эхний 9 сар	2016 оны эхний 9 сар
1	БНХАУ	978,465	1,109,117
2	ОХУ	352,028	411,754
3	БНСУ	54,189	53,627
4	ЯПОН	15,324	16,430
5	АНУ	9,276	10,498
6	ХОНГ КОНГ	10,360	9,409
7	ГЕРМАН	7,389	7,398
8	КАЗАХСТАН	7,823	6,484
9	ТУРК	4,521	3,742

2015 оны байдлаар Монгол Улсын 120 мянган иргэн гадаадад оршин сууж байна. Эдгээр иргэдийн гуравны нэг нь суралцах, мөн гуравны нэг нь ажиллах, үлдсэн хувь нь бусад зорилгоор шилжин явагсад байгаа бол шилжин явагчдын ихэнх нь БНСУ, АНУ, БНЧУ-д оршин суух, ажиллах нь хамгийн өндөр байна.

Гэхдээ гадаадад ажиллаж амьдарч байгаа Монголчуудын бодит тоо дээрх

<sup>7</sup> Монголчууд гадаадын аль улс руу хамгийн их зорчиж байна вэ? Эх сурвалж: Гадаадын Иргэн Харьяатын Газар, Oct 6, 2016. <http://www.shuurhai.mn/127314>

тооноос 2-3 дахин өндөр байх магадлалтай гэдгийг Хил хамгаалах ерөнхий газрын статистикт үндэслэсэн зарим тооцоо харуулдаг.<sup>8</sup> Эндээс БНСУ-д аялах, сурах, ажиллах болон бусад зорилгоор явж буй иргэдийн тоо хэмжээ бусад ОХУ, БНХАУ-аас бусад оронтой харьцуулахад өндөр үзүүлэлтэй байгааг харж байна. Гадаадад тодорхой хугацаанд, ялангуяа удаан хугацаанд суурьшаад эргэж нутагтаа ирсэн мигрантууд уг улсынхаа соёлыг түгээгч болж байдаг. Харин Монгол орны хувьд зөвхөн БНСУ-д зорчих иргэдийн тоо өссөн төдийгүй БНСУ-ын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжүүд олон байх болсон нь соёл түгээх бас нэг сурвалж болж байна.

Монгол орон нь иргэний эрхийг дээдэлсэн ардчилсан улс болохынхоо аливаа улс, үндэстний тусгаар шинжийг хүлээн зөвшөөрч тэгшээр үзэх олон соёлт үзлийг (multiculturalism)<sup>9</sup> хүлээн зөвшөөрдөг нь гадны соёл монголд дэлгэрэх үндэс суурь болж байна. Аливаа үндэстний соёл нь дотроо олон хувилбартай, нэгэн төрөл биш байдалтай байхын хамт үндэстний соёл нь хүн төрөлхтний соёлтой харьцуулахад ялгаа байдаг. Үүнийг соёлын олон талт байдал гэнэ. Улс орны хөгжилд соёлын олон талт байдал, соёлын интеграци нь дэвшил авчирдаг ч, буурай хөгжилтэй улс орнуудын соёл иргэншил зан заншлыг уусгаж, үндэстний соёл устаж үгүй болох талтай гэсэн хоёр талаас нь харж ирсэн байдаг.

Энэхүү судалгааг хийхдээ эерэг, сөрөг талын аль нэгийг төвийлгөн гаргах субъектив байр суурьнаас бус, харин даяаршил явагдаж байгаа энэ цаг үед Солонгосын соёлын давалгааг Монголын залуучууд хэрхэн хүлээж авч байна вэ? гэдгийг гаргахыг зорьж, анкетын судалгаанд 16-45 насны 119 хүн, харин Монголын хүүхэд, залууст үзүүлж буй нөлөөг тодруулан үзэх зорилгоор фокус ярилцлаганд 20-38 насны 11 хүнийг хамруулсан судалгаа хийсэн болно.


Солонгосын соёл залуучуудын амьдралын хэв маяг, соёлын төлөв байдалд хэрхэн нөлөө үзүүлж буйг судлах үүднээс анкетын асуулгыг боловсруулж, судалгаанд ихэвчлэн 15-25 насны (65.5%) залуусыг хамруулсан болно.

<sup>8</sup> Гадаад шилжих хөдөлгөөний нөхцөл байдлын тоон болон чанарын судалгаа хийх ажлын удирдамж. 2016 оны 2-р сарын 29, Даваа гариг, 09:22. Хөдөлмөр, Нийгмийн Хамгаалалын сайт:

<http://www.khun.gov.mn/index.php/mn/newnews/2469-gadadshiljihhudsuhihajlinzar.html>


<sup>9</sup> Multiculturalism-Олон соёлт үзлийн үзэл санаа өрнөдийн олон үндэстэн ястан бүхий улс орнуудад хамаатай ойлголт байсан өнөөгийн глобальчлалын эринд өргөн хүрээг хамрах ойлголт болоод байна. Олон соёлт үзэл нь зөвхөн соёлын хүрээнд олон соёлын шинж хандлага төдийгүй улс төр, эдийн засаг, нийгмийн янз бүрийн салбарыг хамарч, цаашилбал нийгмийн давхарга, жендерийн ялгаа зэрэг асуудалуудыг өөртөө багтаадаг. Тухайлбал тухайн улс орны байр суурийн илэрхийлэл, төрөөс хэрэгжүүлж буй бодлогын чиг хандлага, үндэстнийг нэгдэх үзэл санааг агуулдаг байна. Олон соёлт үзэл 1970-аад оны дунд дэлгэрсэн. Олон соёлт үзэл нь нэг нийгмийн дотор орших үндэстний тус тусын зайлшгүй шинжийг хүлээн зөвшөөрч, улс үндэстний нь хоол, хувцас, шашин, хэл зэргийг тэгшитгэн тэгш байх ёстой гэж үздэг үзэл. Соёлын үнэлэмжийг хүндэтгэн үзэх соёлын олон ургальч үзэлд хувь хүний соёлын ахуй, хувь хүний эрхийг эрхэмлэдэг.

### Хүснэгт 3



Судалгаанд хамрагдагсадын хүйс, боловсролын түвшин зэргийг дараах хүснэгт 4,5-аас үзнэ үү.

#### Хүснэгт 4




#### Хүснэгт 5




Та болон таны гэр бүлийн гишүүдээс БНСУ-д зорчсон хүн байгаа юу? асуултанд 67 хувь нь тийм гэж хариулжээ. БНСУ-ын талаарх хэр мэдлэг, мэдээлэлтэй болохыг асуусан асуултанд судалгаанд хамрагдсын 73 хувь бага зэрэг, 11 хувь сайн, 10 хувь хангалттай гэсэн хариулт өгсөнөөс харахад БНСУ-ын талаар ойлголт, мэдлэг нийт залуучуудын дунд тодорхой хэмжээнд байгааг харуулна.

Нийт судалгаанд оролцогчдын 83 хувь БНСУ-д зорчих хүсэлтэйгээс 70 орчим хувь нь аялах, сурах явах сонирхолтой хэмээн хариулсан байна. Залуусын дунд БНСУ-д сурангаа ажил хийж сургалтын төлбөр, эсвэл амьдрах өртөгөө өөрөө олж болно гэсэн хандлага байдаг нь Солонгост сурах сонирхлыг төрүүлдэг нэгэн шалтгаан болж байгаа нь фокус ярилцлагын явцаас ажиглагдаж байлаа.

### Хүснэгт 6



### Хүснэгт 7




Солонгосын соёлыг хүлээн авч буй хандлагыг харах зорилгоор ТВ нэвтрүүлэг, хувцас, хоол гэсэн соёлын тархалтыг илэрхийлж болох гурван хүчин зүйлийг сонгон авсан анкетын асуулгын дүнтэй танилцъя.

1. Та ТВ-ээр Солонгосын ямар нэгэн хөтөлбөр үздэг үү? асуултанд 74 орчим хувь нь үздэг гэж хариулснаас, кино 47 хувь, танин мэдэхүйн нэвтрүүлэг 11 хувь, хөгжөөнт нэвтрүүлэг 6 хувь, бусад хөтөлбөр үздэг гэж 11 хувь нь хариулсан байна. Хүснэгт 8.

ТВ-ээр Солонгосын хөтөлбөр үздэг вэ?

Ихэвчлэн ямар нэвтрүүлэг үздэг вэ?



2. Ахуйн хэрэглээнд гэр ахуйн болоод гоо сайхны бүтээгдэхүүн гэх мэт болон зүйлийг оруулах хэдий ч залуучуудын дунд өргөн хэрэглээ болох хувцсыг сонгон авч асуултыг тавьсан болно. Та Солонгосын үйлдвэрлэсэн хувцас өмсдөг үү? гэсэн асуултанд залуучуудын 69,6 хувь нь өмсдөг. Хүснэгт 9.

Солонгост үйлдвэрлэсэн хувцас өмсдөг гол шалтгаанаа дийлэнх (52,7%) нь стиль, мод болон чанар гэж хариулсан байна. Хүснэгт 10.

Хүснэгт 9.




Хүснэгт 10.




3. Залуучуудын өдөр тутмын хүнсний хэрэглээнд Солонгос хоол, хүнс хэр нэвтэрснийг харах зорилгоор Солонгос хоол, хүнсэнд дуртай эсэх, хэдий хэмжээтэй хэрэглэдгийг асуулаа. Судалгаанд оролцогчдын 46 хувь орчим нь Солонгос хоол хүнсэд дуртай гэж хариулсан хэдий хэрэглээний давтамж нь тийм ч ихгүй байна. Энэ нь дараах гурван хүчин зүйлтэй холбоотой гэж үзэж байна. Нэг, Солонгос хүнсний бүтээгдэхүүний өртөг өндөр, хоёр, Солонгос зоогийн газрын үнэ их, гурав, гэртээ Солонгос хоол, хүнсийг бэлтгэж хэрэглэж чаддаг хүмүүсийн тоо олон биш зэрэг болно.

Та Солонгос хоол, хүнсэнд дуртай юу?



Та Солонгос хоол, хүнсийг хэр давтамжтай хэрэглэдэг вэ?



Дээрх судалгааны дүнгээс харахад өнөөдөр Монголын залуучуудын дунд Солонгосын соёлын бүтээгдэхүүний эрэлт, хэрэгцээ зах зээл хэдийнэ бий болжээ. Монголын залуусыг сэтгэлийг татдаг Солонгосын соёлыг хүргэж байдаг урлагын төрөл нь кино, драм, К-поп хөгжмийн урсгал байна. 1996-1997 оны үеэс ТВ-ээр Солонгосын олон ангит кино гаргах болсноос хойш өнөөдрийг хүртэл тасралтгүй гарч, харин ч ТВ-ын кино хөтөлбөрийн ихэнх хувийг эзэлсээр байна.

Техник технологи хийгээд интернетийн хөгжил нь дэлхий даяар К-пор<sup>10</sup> урсгалыг шүтэгсдийн тоог улам нэмэгдүүлсэн хүчин зүйл гарцаагүй мөн. Монголын хүүхэд залуучууд ч тэдний нэг хэсэг гэхэд болно. Учир нь Солонгосын К-поп урлагийн томоохон төлөөлөл болсон хэд хэдэн хамтлаг, дуучид Монголын тайзнаа тоглолтоо өргөн барихад тоглолтын талбай дүүрэн үзэгчидтэй байсан нь энэ чиглэл хэдийнээ хөгжсний нэг илрэл болсон. Энэхүү урлаг, соёлын хөгжил нь залуусын хувцаслалт, амьдралын хэв маягт ч нөлөө үзүүлж байна. Судалгаанд оролцсон залуусын 29,6 хувь нь солонгос хувцсыг мода, стилиэс болж хэрэглэдэг гэсэн хариултыг өгсөн. Түүнчлэн Солонгос хоолны онцлог, кимчиний тухай сонсоогүй, үзээгүй залуус байхгүй төдийгүй сонгож хэрэглэх хоол, хүнсний бүтээгдэхүүн болсныг судалгааны дүнгээс харж болно.

Фокусын ярилцлагыг Монголын залуучуудад Солонгосын соёл үзүүлэх нөлөө сэдвийн хүрээнд өрнүүллээ. Ярилцлаганд оролцсон зарим хүмүүсийн кейс яриа анхаарал татсан юм.

**Кейс 1. Э:** ... би хамаатныхаа дүүгийн хуриманд очоод төрсөн сэтгэгдлээ ярья. Дүүгийн урилганд хурам болох газрыг хуримын ордонд бус, харин христийн сүмд болно гэсэн байлаа. Би гайхаж очих эсэхээ мэдэхгүй эргэлзсэн ч, урилгыг хүлээн авсан болохоор гэр бүлийхний хамт ёслолд очсон. Бидний очсон сүм Солонгосын хөрөнгө оруулалттай бололтой, номлогч Солонгос хүн байсан юм. Хуримын ёслолын үйл явц нь нарийн дэг ёстой, хурим хийж буй хүмүүс бие биеийнхээ өмнө хариуцлага хүлээх, хамтдаа зовлон жаргалаа хуваалцахаар андгай авч байсан. Христийн урсгал чиглэл цаашдын нөлөөг нь мэдэхгүй ч, харин хурмын ёс нь хуримлаж буй хүмүүст гэр бүл болох нь тоглоом биш, маш их хариуцлага хүлээдгийг мэдрүүлэх үйл явц болохыг мэдэрсэн.

**Кейс 2. Б:** ... манай охин Солонгосын хөрөнгө оруулалттай “Улаанбаатар” ЕБС-д сурч байсан. Тэдний сургууль нь ахмад үеэ хүндлэх, бусдадтай мэндлэх, хүмүүсийг ялгаварлан үзэхгүй, мөнгөөр аливааг харахгүй байх зэрэг хүүхдийг зөв хүмүүжилтэй болоход сайн нөлөө үзүүлдэг гэж би боддог. Миний бодлоор солонгосчуудын суурь хүмүүжлийн хэлбэр нь ‘Family background’ байдаг юм шиг санагддаг.

---

<sup>10</sup> БНСУ-д 1990-ээд оны дунд үеэс эхлэн Барууны электро поп, хип-хоп, орчин үеийн R&B зэрэг хөгжмийн урсгалуудыг бүхэлд нь нэгтгэсэн шинэ урсгал бий болов. Уг хөгжмийн урсгал дэлхий даяар маш идэвхтэй хөгжиж буйд гайхсан Бээжингийн сэтгүүлчид К-пор хэмээн нэрлэх болжээ. Эхлээд зөвхөн хөгжмийн урсгалын чиглэлээр үүссэн К-пор өнөөдөр дэлхийн сая сая залуучуудын шүтээн болсон төдийгүй өсвөр насныхны дунд өдгөө бүхэл бүтэн стиль, хэв маяг, соёлын хэмжээнд хүртлээ өргөжсөн байна.

**Кейс 3. Ц:** ... Солонгосчуудаас суралцах зүйл их байдаг. Би Солонгост сурч, гэр бүлээрээ хэдэн жил амьдарсан. Солонгос хүмүүс ажлын ачаалал даадаг, ажлаа төлөвлөж хийж чаддаг, тусархуу, ахмад болон дээд тушаалын хүмүүстээ захирагдаж хүндэлдэг гээд дурдвал олон зүйлийг хэлж болно. Энэ бүгд нь манай залууст хэрэгтэй. Гэхдээ соёлын нөлөөний сайн бус саар нь илүү амархан дэлгэрч байдаг юм шиг санагддаг. Жишээ нь, нийтийн унаанд солонгосоор хараал хэлж буй хүмүүстэй хэдэнтээ таарсан.

**Кейс 4. Т:** ... соёлын нөлөөллийг Солонгостой адилхан стилээр хувцаслаж, солонгос хоол идэж, хэдэн үг мэддэг болсоор ойлговол өрөөсгөл болох байх. Үүний цаана үндэстний өвөрмөц онцлог томоохон сэтгэлгээний хэв маяг байгаа гэдгийг бодох хэрэгтэй. Тэр нь л Монголын залууст хэрхэн нөлөөлж байгааг судлах хэрэгтэй байх.

**Кейс 5: Б:** ... Солонгосын бүх юм гоё сайхан гэх ойлголт залуусын заримд байдаг. Гоо сайхны хагалгаа хийлгээд сайхан болчихно, Солонгосын үйлчилгээний соёл нь гоё, Солонгос хүнтэй гэрлэвэл сайхан амьдарна гээд бодох нь бий. Тэгэхээр энэ талаар судлаж хүүхэд залууст зөв мэдлэг мэдээлэл өгөх нь чухал. Фокус ярилцлаганд оролцогсад өөрийн өөрсдийн үзэл бодлоо нээлтэй хуваалцаж бидний амьдралд гадны соёл, ялангуяа Солонгосын соёл хэрхэн нөлөө үзүүлж байгаа тухай ярилцсан юм. Ярилцлагын үр дүнгээс харахад хүүхэд, залуус шинэ соргог зүйлд татагдах хэлбэрээр Солонгосын соёлд хандаж байгааг олон хүн хэлж байлаа.

## Дүгнэлт

Даяаршлын үйл явц дэлхий дахинд хэрхэн өрнөх, түүний үр дагавар ямар байгаа талаар судлаачид өөр өөрийн үзэл бодлоо илэрхийлж байна. Иргэншил хоорондын мөргөлдөөн номын агуулгад хүйтэн дайны дараахи зөрчил сөргөлдөөний үндэс эдийн засаг, улс төрийн үзэл суртал бус харин соёлын иргэншлийн сөргөлдөөн байна гэсэн нь зарим талаараа биелэлээ олж байгаа мэт. Өнөө үед иргэншил хийгээд соёлын нэгдэл, эсрэгцэл хүчтэй явагдаж байна. Томоохон соёл иргэншлийг жижиг соёлыг устгах хүч хэмээн харж байна. Гэхдээ профессор Аржун Аппадурайгын соёлын нэгдэл бус, олоншил явагдаж буйтай санал нийлж байна. БНСУ-ын соёлын нөлөө Монголд тархаж байгаа нь нэгдших хэлбэрээр бус харин, олонших үйл явц гэж тодорхойлохуйц байна. Тухайлбал, Монголд байх Солонгос ресторанд ороход хоолны нэр, хэлбэр зэрэг нь төстэй ч амт, чанар нь өөр болж үйлчлүүлэгчийн сонирхолд нийцүүлэн монголчилсон нь ажиглагддаг.

Сүүлийн жилүүдэд Монгол улс, БНСУ-ын харилцаа, хамтын ажиллагаа өргөжиж байгаа нь Монголд Солонгосын соёл урлаг, шашин, шинжлэх ухааны салбарын хөгжил хурдацтай явагдах суурь хөрс болж байна. Дээрх судалгааны үр дүнгээс Монголд дэлгэрч буй Солонгосын соёлыг залуусын уламжлалт үнэт зүйлсийг өөрчлөгдөхүйц хэмжээнд бус, харин “хэрэглээний түвшинд хөгжиж буй соёл” гэсэн дүгнэлтийг хийж байна. Харин дээрх анкетын болон фокус ярилцлагын судалгааны үр дүнд суурилан SWOT analysis хийж үзэхэд:

Давуу талууд (Strengths)	Сул талууд (Weaknesses)	Боломжууд (Opportunities)	Аюулууд (Threats)
<ul style="list-style-type: none"> <li>• Хөгжингүй орны соёлоос суралцах</li> <li>• Үндэсний уламжлалт соёлтой харьцуулах</li> <li>• Өөрийн соёлын өвөрмөц талыг танин мэдэх,</li> <li>• Үндэсний соёлын үнэт зүйлсийг үнэлэх</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Уламжлалт соёлын нөлөө сулрах</li> <li>• Уламжлалт соёлоос гадны соёлыг илүүд үзэх</li> <li>• Уламжлал, ёс заншлыг үл хүндэтгэх</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Олон талт соёлыг дэлгэрүүлэх</li> <li>• Уламжлалд шинэчлэлт хийх</li> <li>• Солонгосын соёлоос суралцах</li> <li>• Соёлын нөлөөгөөр эерэг зан үйлд суралцах</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Гадны соёлыг хэт туйлшран үзэх</li> <li>• Соёлын буруу урсгал чиглэлд уруу татагдах</li> <li>• Хүнийсэх</li> <li>• Үндэсний уламжлалт соёлыг үгүйсгэх</li> </ul>

Аливаа орны хүүхэд, залуучууд нь гадны соёлыг нөлөөг хүлээн авч, түгээн дэлгэрүүлэх гол объект байдаг. Иймээс цаашид Монголд дэлгэрч буй гадны соёлын чиг хандлага нөлөөг судлах, үндэсний соёлыг дархлааг дэмжих, ялангуяа гаднаас орж ирж буй шашны буруу урсгал чиглэл, зарим соёлын гаж маягийн зан үйл зэрэг сөрөг соёлын нөлөөнд хүүхэд, залуусыг автахаас урьдчилан сэргийлэх нь чухал болж байна. Энэ нь хэрэглээний түвшинд соёлын олоншил бий болж буй асуудлаас огт өөр гэдгийг анхаарах хэрэгтэй юм.

## Ашигласан бүтээл

1. Ц. Батцэрэн. Монголия: Влияние трансграничной трудовой миграции на воспитание детей. Восток на востоке, в России и на Западе трансграничные миграции и диапоры. Санкт-Петербург. 2016
2. Ц. Батцэрэн. “Олон соёлт үзэл: Солонгосын иргэдтэй гэр бүл болсон эмэгтэйчүүдийн жишээн дээр. Даяаршлын үеийн соёл ба миграци. Олон улсын хурлын эмхэтгэл, УБ. 2012
3. Г. Мөнх-Эрдэнэ. “Даяаршил шинэ колонизм биш: Монгол дахь олон талт байдал”, Даяаршлын үеийн соёл ба миграци. Олон улсын хурлын эмхэтгэл, УБ. 2011.
4. А. Энхбаатар, Б. Пүрэвсүрэн. Даяаршлын нөхцөл дэх шилжилт хөдөлгөөн ба соёлын эрх чөлөө. Даяаршлын үеийн соёл ба миграци. Олон улсын хурлын эмхэтгэл, УБ. 2012.
5. А. Син. Орч. Хөгжил бол эрх чөлөө. УБ. 2014.
6. Гадаад шилжих хөдөлгөөний нөхцөл байдлын тоон болон чанарын судалгаа хийх ажлын удирдамж. 2016 оны 2-р сарын 29, Даваа гариг, 09:22. Хөдөлмөр, Нийгмийн Хамгаалалын сайт:
7. <http://www.khun.gov.mn/index.php/mn/newnews/2469-gadadshiljihhudsubihih-jlinzar.html>
8. Монголчууд гадаадын аль улс руу хамгийн их зорчиж байна вэ? Эх сурвалж: Гадаадын Иргэн Харьяатын Газар. Oct 6, 2016. <http://www.shuurhai.mn/127314>
9. Самуэл Хантингтон. Орч. Иргэншил хоорондын мөргөлдөөн, Ази-Америкийн хүйтэн дайн
10. Уналан, 2005. “EUROSTAT” байгууллага болон Нидерландын хүн ам зүйн салбарын хүрээлэн /NIDI/ нарын хамтран хийсэн “Олон Улсын Шилжилт Хөдөлгөөний Түлхэх болон Татах хүчин зүйл” судалгааны бүрэлдэхүүн хэсэг.
11. Jacques Delors. Questions concerning European Security, Adress, International institute for Strategic Studies, Brussels, 10 September 1993.
12. Henry A. Kissinger. Diplomacy, New York: Simon& Schuster, 1994.
13. Vaclav Havel. The New Measure of Man, New York Times, 8 july 1994.
14. 박이문. 문화다원주의 철학과 현실
15. 이용승. 호주의 다문화주의 동아시아연구, 2004.